

12

АРИЛЖААНЫ БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТӨРӨЛ, МОНГОЛЫН ОНЦЛОГ

П.Оюунбилэг

Банк нь хадгаламж эзэмшигчдийн хадгалуулсан мөнгийг зээл хүсэгчдэд олгож байдаг нь санхүүгийн зуучлагчийн үүргээ гүйцэтгэж байгаа хэрэг юм. Банкны энэ үйл ажиллагаа нь хадгалуулагч, зээлдэгч аль алины нь ашиг сонирхолд нийцэж байдаг. Хадгалуулагч хүү авч, зээлдэгч мөнгийг хүссэн хугацаагаар ашиглаж, банк эдгээр сонирхлуудын дундаас ашиг олж байдаг нь мэдээжийн хэрэг юм. Өөрөөр хэлбэл банк нь хадгаламж эзэмшигчид төлж байгаа хүүнээс илүү хүүтэйгээр зээлдэгчид мөнгийг зээлдүүлж дундаас нь ашиг олдог гэсэн үг юм. Үүнээс үндэслэн банк байгуулах үндсэн гол зорилго нь харилцагчдад зээл олгох явдал гэж хэлж болно.

Банкууд зээлийн багцаа оновчтой удирдахын тулд зээлээ ангилж төрөлжүүлэх болно. Банкны зээлийн төрөл нь тухайн улсын эдийн засгийн хөгжлийн түвшингээс нэлээд хамаардаг байна.

Арилжааны банкны зээлийг олон улсын практикт:

- зориулалтаар
- хугацаагаар
- салбараар
- хүүгээр
- барьцаагаар
- хэмжээгээр
- төлөгдөлтөөр
- зээлдэгчээр
- чанараар гэх мэт маш олон янзаар ангилдаг байна.

Манай банкны практикт зээлийг **зориулалтаар** Худалдаа үйлдвэрийн, Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалах, Иргэдийн, Улсын болон төрийн байгууллагуудад олгох, Банк бус санхүүгийн байгууллагуудад олгох, Хөдөө аж ахуйн. **Хугацаагаар** Богино, Дунд болон урт хугацаат **Хүү** тогтмол. **Салбараар** Аж үйлдвэр, Хөдөө Аж ахуй, Худалдаа, Тээвэр, холбоо. **Барьцаа**

баталгаагаар батлан даалттай, барьцаатай. **Хэмжээгээр** Жижиг, Дунд, Том. **Төлөгдөх байдлаар** Зээлийн төлөгдөх хугацаа болмогц зээл хүүгийн хамт төлөгдөх, Хүүгээ сар бүр, зээлээ хугацаа дуусмагц төлөх, Зээлээ хүүгийн хамт хэсэгчлэн сар бүр төлөхөөр. **Зээлдэгчээр** Хувийн болон иргэдийн, Аж ахуйн нэгж байгууллагуудын, Улсын үйлдвэрийн газрын. **Чанараар** Хугацаандаа байгаа буюу хэвийн, Хугацаа хэтэрсэн, Хэвийн бус, Эргэлзээтэй, Муу зээл гэж ангилж байна. Гэтэл олон улсын практикаас харахад зах зээл хөгжсөн орны зээлийн тархац жигд, олон талыг хамарсан, өргөн хүрээтэй байдаг байна.

Манай орны хувьд арилжааны богино хугацаатай, тогтмол хүүтэй зээл голчилж, үл хөдлөх хөрөнгийн болон хувийн зээлийн эзлэх жин доогуур байна. Мөн түрээсийн үйлчилгээний төрөл, үнэт цаасны хөрөнгө оруулалт хөгжөөгүй байгаа нь ажиглагдаж байна.

Сүүлийн үед манай арилжааны банкууд шинэ төрлийн зээл олгохыг эрмэлзэх хандлагатай болжээ. Анод, Эрэл, Улаанбаатар хот зэрэг зарим арилжааны банкууд орон сууцны санхүүжилттэй холбоотой зээл олгож эхэлж байгаа ч энд шүүмжлэлтэй хандах нэг асуудал нь зээлийн хугацаа нэлээд богино (1-2 жил) байгаа явдал юм. Энэ нь эрсдэлтэй зээл үүсэх хандлагыг бий болгож болох талтай. Учир нь орон сууцны зориулалтын зээл нь хөрөнгө оруулалтын зээл учраас хугацаа урт байх нь зүйтэй.

Урт хугацаат зээл нь богино болон дунд хугацаат зээлийг бодвол зээлдэгчийн үйл ажиллагааны гадаад дотоод хүчин зүйлсийн нөлөө, нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурь, улсын эдийн засгийн чиг хандлагаас ихээхэн шалтгаалдаг тал бий.

Одоогийн байдлаар манай арилжааны банкууд урт хугацаат зээл өөрийн эх үүсвэрээрээ бараг олгохгүй байна. Харин тодорхой төслийг хэрэгжүүлэх, төндөрт шалгарсан гадаад орны зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих арга хэмжээг Засгийн газар хоорондын хэлэлцээр, гадаадын эрх бүхий байгууллагуудтай хийсэн зохих ёсоор батламжлагдсан, хугацаа нь хүчин төгөлдөр хэлэлцээрийг үндэслэн эх үүсвэрийг банк төвлөрүүлж урт хугацаат зээлийг олгож байна. Банкууд өөрийн эх үүсвэрээрээ урт хугацаат зээл олгохгүй байгаа явдал нь арилжааны банкуудын болгоомжлолтой холбоотой байж болно. Арилжааны банкуудын Төв банкинд болон гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө нь нийт зээлийн дүнтэй ойролцоо байгаа нь үүнийг нотолж буй хэрэг юм. Ийм болгоомжлол байхыг үгүйсгэх аргагүй ч нөгөө талаар энэ нь удаан үргэлжилж болохгүй гэдэг нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл арилжааны банкууд урт хугацаатай, бодлогын чанартай зээл олгохгүй байх явдал нь үндэсний үйлдвэрлэл хөгжихгүй байх, ажилгүйдэл буурахгүй байх зэргээр нийт эдийн засагт сөрөг нөлөөтэй. Үүнийг өөрчлөхийн тулд зээлийн шинжилгээг чанартай сайн хийж, зээл олгохын өмнө, мөн зээл олгосны дараахь хяналтыг сайжруулан, зээлийн хүүг эрс бууруулах хэрэгтэй.

Хүснэгт 1

Банкны зээлийн хүү (жилээр, хувиар)

	1995 он	1996 он	1997 он	1998 он	1999 он	2000 он
Монгол банкны зээлийн хүү	72-150	72-109	45-50	23.3	11.4	8.6
Богино хугацааны зээлийн хүү	54.7	48.8	50.4	45.8	38.8	34.7

Нийт эдийн засаг жилд дунджаар 3-4 хувь өсч байхад жилийн 30-аас дээш хувийн хүүтэй зээлийг дааж чадах төсөл хэрэгжиж чадахгүй гэдэг нь ойлгомжтой.

Зээлийн хүүгийн асуудал нь зээлийн хугацаатай салшгүй холбоотой. Урт хугацаат зээлийн хүү өндөр, богино хугацаат зээлийн хүү бага байдаг байна. Мөн зарим тохиолдолд байнгын үйлчлүүлэгчид хүүгийн хөнгөлөлт авах нь ч бий. Зээлийн хүүг манай орны хувьд голдуу

зээлийн үлдэгдлээс бодож авч байна. Энэ нь ихэвчлэн богино хугацаатай зээл олгодогтой холбоотой. Харин зах зээл өндөр хөгжсөн орнуудад зээлийн хүүг бодох олон аргууд байдаг. Зээлийн хүү нь мөнгөний зардал буюу мөнгөний үнэ юм. Ерөнхийдөө зээлийн хүү = нийт зардал + ашиг гэж тооцох боловч нийт зардал, ижил төстэй банкуудын хандлага, зээлийн хугацаа, тогтоож буй хүү банк болон зээлдэгчийн эдийн засгийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзэж зээл бүрт хүү нь тохирсон байхаар хувьсган тооцоологдог практик байдаг байна.

Манай арилжааны банкуудын хувьд зээлийн хүү тогтмол, өндөр байдаг нь зээл эргэн төлөгдөхгүй байхын гол биш ч тодорхой нэг шалтгаан болж байна. Олон улсын практикт арилжааны банкууд том зээл олгохыг эрмэлздэг. Дунд болон том зээл олгоход зардал бага байдаг ч эрсдэл өндөр болох талтай. Харин жижиг зээл олгоход зардал өндөртэй ч эрсдлийн түвшин бага байдаг. Эндээс зээлийн хэмжээ ашигт ажиллагаатай шууд хамааралтай болохыг харж болно.

Иймд банкууд ашгаа нэмэгдүүлэхийн тулд аль болох цөөн зээлдэгчид их хэмжээний зээл олгохыг эрмэлздэг. Гэтэл зээлдэгч бүр найдвартай байдаггүй тул зээл эргэж төлөгдөхгүйд хүрэх аюултай. Энэ байдлыг зохицуулахын тулд Төв банк нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг тогтоож өгдөг байна. Одоо манай арилжааны банкууд голдуу том буюу дунд хэмжээний зээл олгохыг эрмэлзэж байна. Арилжааны банкууд хөрөнгөгүйдээ бус найдвартай зээлдэгч олоход хэцүү учир дунд болон урт хугацааны зээл олгож чадахгүй байна гэсэн дүгнэлт хийж болно.

Банк нь зээлдэгчийн үйл ажиллагааны явц үр дүнд хяналт тавиад зогсохгүй зээлдэгчийн зээлээ төлөх хүсэл эрмэлзлэл нь ямар байгаад байнга анхаарлаа хандуулж байх хэрэгтэй. Зээл төлөхгүй тохиолдолд банк төдийгүй тухайн зээлдэгч ямар хохирол амсахыг зээлдэгчид ойлгуулах нь чухал. Ер нь зээл хугацаандаа төлөгдөхгүй болсон тохиолдолд хамгийн их хохирогч нь зээлдэгч байдаг. Учир нь зээлийн өр, хүүний төлбөр дээр хугацаа хэтэрсний торгууль, хүү нэмэгдэж хохирдог. Банк мөн адил тухайн зээлдэгчид олгосон зээлийн хөрөнгөө хэд дахин эргүүлэх боломжоо алдана. Иймд зээлийг төлүүлэх үйл ажиллагаанд банк онцгой анхаарал тавьж ажиллах хэрэгтэй болдог. Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд зээл олголтод тавих хяналтыг хүчтэй болгож, өмнө олгосон зээлээ төлүүлэх талаар анхаарч ажилласны үр дүнд зээлийн өрийн үлдэгдэл буурч байгаа боловч зээл олголтод тавих хяналтыг улам боловсронгуй болгож, зээлдэгчийн хариуцлагыг дээшлүүлэх нь улам бүр шаардлагатай болж байна.

2000 оны эцсийн байдлаар банкны системийн нийт зээлийн өрийн үлдэгдэл 67.8 тэр бум төгрөг байгаагийн 15.9 тэр бум төгрөг нь хугацаа хэтэрч, чанаргүй зээл болжээ. Чанаргүй зээлийн хувийн жин 1999 оныхоос 11 хувиар буурсан байна. Ер нь зээлдэгчийн эдийн засаг, санхүүгийн байдлыг зээлийг олгохоос өмнө хэрхэн зөв үнэлж дүгнэснээс зээлийн багцын чанар шууд хамаардаг гэдгийг анхаарах шаардлагатай.

Манай банкны практикт хэрэгжүүлж болох хэд хэдэн зээлийн төрлийг санал болговол:

- **Хувь хүнд олгох зээл:** хэрэглээний, үйлчилгээний, оюутны, бэлэн нөөцийн данс нээлгэх, зээлийн карт эзэмшигчийн гэсэн шинэ хэлбэрүүд байна.
- **Хэрэглээний зээл:** нь хувь хүнд удаан эдэлгээтэй өргөн хэрэглээний барааг худалдан авахад зориулж олгогддог ба гол төрөл нь автомашин, бусад эд хогшил, эргэлтийн шинжтэй бараа ордог байна. 1980-аад оны сүүлчээр гэхэд АНУ-ын арилжааны банкууд дахь хэрэглээний зээлийн үлдэгдэл 27.22 тэрбум ам.доллэр байсаны 39 хувийг автомашин худалдан авахад зориулсан зээл эзэлж байсан байна. Манай оронд хэрэглээний зээл өмнө нь маш бага олгогддог байсан бол одоо Улаанбаатар хот банк ийм

зээл олгож эхлээд байна. Улаанбаатар хот банкны энэ зээлийн зориулалт нь гол төлөв залууст өндөр үнэтэй удаан эдэлгээтэй бараа худалдан авахад нь туслах явдал юм.

- **Үйлчилгээний зээл** нь эмчилгээний төлбөр хийх зэрэгт зориулагддаг.
- **Оюутны зээл** нь боловсрол олоход зориулж олгодог зээл юм. Зээл авагч нь дээд боловсрол эзэмшихээс өмнө зээлээ төлөх албагүй. Харин энэ зээлийг сургуулиа төгсөөд төлөөгүй тохиолдолд нэлээд өндөр хүү тогтоодог байна. Энэ зээлийг мөн төгссөн хойноо цалин багатай мэргэжлийг оюутан эзэмшихэд чиглүүлдэг байна. Энэ чиглэлээр арилжааны банкны зээл олгогдвол манайх шиг хүн амын нэлээд хэсгийг оюутан залуус эзэлдэг оронд эрэлт ихтэй байх талтай.
- **Бэлэн нөөцийн данс нээлгэх** хэлбэр нь хувь хүнд олгох зээлийн нэг хэлбэр юм. Ийм данс эзэмшигч нь хүсвэл дансны үлдэгдлээ хэтрүүлж болдог. Энэ тохиолдолд банк зөрүүг зээлээр тооцдог. Гэхдээ хүү нь нэлээд өндөр байдаг. Зээлийн энэ төрлийг хэрэгжүүлбэл их хэмжээний бэлэн мөнгө авч явдаг эрсдлээс гарч болох сайн талтай.
- **Банкны зээлийн карт** Кредит картын үйлчилгээ нь хэрэглээний зээлийн томоохон хэсгийг эзэлдэг. Зээлийн карт эзэмшигч нь орлогоосоо хамааран, банктай тохиролцсоны үндсэн дээр тодорхой хэмжээний зээлийг ашиглах боломжтой. Зээлийн картаар үйлчлүүлэгч нь жижиглэн худалдааг уг картаар хийдэг бол зарим хязгаарлалтууд тогтоодог.
Үүнд:
 - Тодорхой хугацаанд худалдаа хийх нийт мөнгөний хэмжээ
 - Нэг удаа худалдаа хийх хэмжээ
 - Хадгаламжийн мөнгөний хамгийн бага хэмжээ
 - Өрийн үлдэгдлийн хамгийн дээд хэмжээ гэх зэрэг.

Зээлийн картын үйлчилгээ зохих төлбөртэй байдаг. Банкны зээлийн картыг дараахь байдлаар гаргаж болдог. Үүнд:

- Харилцагч үндсэн банк нь дагнан гаргах
- Харилцагч үндсэн банкиг төлөөлөн ХХК (limited agent) гаргах.

Зээлийн картын эрх бүхий төрөлжсөн компаниуд гаргах. Үүний гол төлөөлөгч нь Американ Экспресс компаний карт юм. Энэ нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, түгээмэл болсон алдартай картын систем юм.

Манай улсад зарим арилжааны банкууд өөрийн нэрийн өмнөөс зээлийн карт гарган ашиглуулж байсан боловч картыг түгээмэл хэрэглэхэд аюулгүй ажиллагааг хангах мэдээллийн нэгдсэн сүлжээ байхгүй, мөн хууль зүйн орчин бүрдээгүй зэрэг учир шалтгаанаас болж хөгжиж чадахгүй байна.

Лизингийн зээл: Банк нь шаардлагатай тоног төхөөрөмжийг хэрэглэгчдэд худалдан авч өгөөд түрээсийн төлбөр авдаг нь зээлийн нэг шинэ хэлбэр болжээ. Нөгөө талаас энэ түрээс нь хэрэглэгч томоохон хөрөнгө оруулахгүйгээр тоног төхөөрөмж авах боломжийг олгодог сайн талтай. Энэ тохиолдолд банк нь түрээсийн төлбөр авахаас зээлийн хүү авахгүй. Лизингэд автомашин, албан тасалгааны тоног төхөөрөмж, тавилга, компьютер, суурь машин зэрэг хамрагддаг байна. Манайд лизингийн зээл хэрэгжүүлэх анхны оролдлогыг Голомт банк санаачилсан боловч хууль эрх зүйн орчин бүрдээгүйн улмаас хөгжих нь удаашралтай байна.

Эд бүгдээс үндэслэн дүгнэлт хийхэд зах зээлийн нөхцөлд банкны зээлийн нэр төрлийг олшруулж, дэвшилттэй хэлбэрүүдийг нэвтрүүлэх явдал нь зээлийн эрсдлийг бууруулж, зээлийн багцын чанарыг дээшлүүлж, зээлийг оновчтой удирдахад сайн талтай байна.